



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/578

Алтай хот

**Төрийн байгууллага, албан хаагчдын эх  
хэлний зохистой хэрэглээг дэмжих аян  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлигийн “А” хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллага, албан хаагчдын эх хэлний зохистой хэрэглээг дэмжих аяныг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулж, удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг “Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийн “Хос бичигтэн” арга хэмжээнээс зарцуулж, хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Аяны удирдамжийн дагуу сум, байгууллагууд төлөвлөгөө гаргаж, үр дүнтэй тодорхой арга хэмжээ зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны  
09 дүгээр сарын 13-ний өдрийн 1578 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧДЫН ЭХ ХЭЛНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ АЯНЫ УДИРДАМЖ

### ЗОРИЛГО:

Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйл, 6.1.1 дэх заалт, 8 дугаар зүйл, 8.1 дэх заалт, 17 дугаар зүйл, 17.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын эх хэлний болон албан хэрэг хөтлөлтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд оршино.

### ЗОРИЛТ:

- ✓ Сургагч багш нарыг чадавхжуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- ✓ Төрийн албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт бүрдэл хангалтыг сайжруулах
- ✓ Төрийн албан хаагчдын зөв бичгийн дүрэм, найруулга зүйн мэдлэгийг дээшлүүлэх
- ✓ Төрийн байгууллагуудын гадна болон дотор хаягийг хос бичгээр бичиж байршуулах

### ХАМРАХ ХҮРЭЭ:

Аймгийн төрийн байгууллага, албан хаагчид, эх хэлний багш нар

Хугацаа: 2022 оны 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 15

### ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Сургагч багш бэлтгэх арга зүйн сургалт (9 сарын 15,16)
  - 1.1 Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудалд
  - 1.2 Монгол хэл, бичгийн сургалтын арга зүй
  - 1.3 Монгол хэлний найруулга зүй

Сургалтад аймгийн монгол хэл уран зохиолын судлагдахууны 50 багш хамрагдана.

Сургалтыг Монгол улсын зөвлөх багш нар, үндэсний сургагч багш нар удирдан чиглүүлнэ.

1. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт (09.18-10.15)
  - 1.1. Монгол хэлний нийтээр баримталж буй зөв бичих дүрэм

- 1.2. Монгол хэлний найруулга зүй, Албан бичгийн найруулга
- 1.3. Албан хэрэг хөтлөлт
- 1.4. Баримт бичгийн стандарт, бүрдэл хангалт

Сургалтыг батлагдсан хуваарийн дагуу ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш нар болон Архивын тасгийн ажилтнууд, сумдын Засаг даргын Тамгын газар, агентлагуудын архив, бичиг хэргийн эрхлэгч нар зохион байгуулж явуулна.

2. Төрийн байгууллага тус бүр аяны хүрээнд албан хаагчдыг идэвхжүүлэн чадваржуулах эх хэлний болон албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдолтой хөгжөөнт, танин мэдэхүйн уралдаан тэмцээн санаачлан зохион байгуулах
3. Төрийн байгууллагыг кирил болон үндэсний хос бичгээр хаягжуулах
4. Сургалт зохион байгуулсан сэдвийн агуулгаар шалгалт авах /10.15-10.25/

**ТАЙЛАН ХҮЛЭЭН АВАХ:** Зохион байгуулсан ажлын тайланг 2022 оны 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлд ирүүлнэ. Хугацаа хоцорсон тайланг хүлээн авахгүй.

**ДҮГНЭХ:** Байгууллага бүрийн албан хаагчдын шалгалтын гүйцэтгэлийн дундаж, байгууллагын хаягжилт, зохион байгуулсан ажлын цар хүрээ, үр дүнг харгалзан нэгдсэн дүнг гаргана.


Жич: Шалгалтын дүнгийн гүйцэтгэлийн дунджийг бодохдоо байгууллагын албан хаагчдын тооны харьцааг харгалзан дүгнэнэ.

#### **ШАГНАЛ УРАМШИЛ:**

Тэргүүн байр-2 /сум, байгууллага/ Өргөмжлөл, 500.000 төгрөг  
Дэд байр-2 /сум, байгууллага/ Өргөмжлөл, 300.000 төгрөг  
Гутгаар байр-2 /сум, байгууллага/ Өргөмжлөл, 200.000 төгрөг  
Тусгай байр-2 /сум, байгууллага/ Өргөмжлөл, 100.000 төгрөг

#### **ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар



Аймгийн Засаг даргын 2022 оны  
 09 дүгээр сарын 13-ний өдрийн 7/598 дугаар  
 захирамжийн хоёрдугаар хавсралт

Говь-Алтай аймгийн төрийн байгууллага,  
 албан хаагчдын "Эх хэлний зохистой хэрэглээг дэмжих"  
 аянд зарцуулагдах хөрөнгийн тооцоо

№	Зардлын нэр		Тоо хэмжээ	Нэгжийн дүн	Нийт дүн	
1	Сургагч багшийг чадавхжуулах сургалт	Хичээл заасан багшийн хөлс / Зөвлөх багш -2, тэргүүлэх багш-6/	8	200000	1600000	4,500,000
		Сургалтын материалын зардал	124	18000	2232000	
		Бичиг хэргийн зардал	1	30000	30000	
		Замын зардал	18	638000	638000	
2	Төрийн албан хаагчдын сургалт	Сумдын төрийн байгууллагуудад хичээл заах цагийн хөлс	114	19*50000	950000	3,350,000
		Аймгийн төвийн байгууллагуудад хичээл заагч багшийн цагийн хөлс /3 багш/	65	30000	1950000	
		Архивын ажилтны хичээл заасан цагийн хөлс	3	150000	450000	
3	Төрийн албан хаагчдын шалгалт		4280	350	1,498,000	
4	Шагнал урамшуулал/ мөнгөн шагнал	1-р байр 500.000*2		8	2,600,000	
		2-р байр 400.000*2				
3-р байр 300.000*2						
тусгай байр 100.000*2						
	Өргөмжлөл		45000	8	360,000	
	Нийт дүн				12,308,000	



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА О.АМГАЛАНБААТАР ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА О.АМГАЛАНБААТАР ТАНАА

ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ  
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАН

Холбоо барих хаяг: Сүхбаатар дүүрэг  
Хангайн төв сургуулийн тосго  
Утас: 25 1727 www.hanlizuvii.mn  
E-mail: hanlizuvii@gmail.com

№: 11/2022  
Хугацаа: 2022.08.25 - 2022.08.25

Эх хэлний өдрийг тэмдэглэх  
нүхэй

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 25 дугаар зарлиг ёсоор "Эх хэлний өдөр"-ийг жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний өдөр уламжлал болон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, бүх шатны сургалтын байгууллагууд ард иргэд тэмдэглэж заншсан билээ.

Уг зарлигийн биелэлтийг ханган ажиллах хүрээнд Засаг дарга нар төрийн болон захиргааны албан бичиг хэрэг хөтлөлтийг монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын хэлний хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг орон нутаг дахь Ажлын газарт чиглэл өгч зарлигийн "а" хэсэгт заасны дагуу 2 сарын хугацаатай аян өгнө гэж ажиллахыг төрийн байгууллагуудад уламжилж өгнө үү.

Зарлигийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газарт Нэгтгэн 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хэлний Боловсролын үндэсний зөвлөлийн Ажлын албанд ирүүлнэ үү.

ДАРГА

НИНАРАНГӨРӨЛ